

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.6 дугаар зүйл, Тэнгэр даатгал компанийн дүрмийн 7.4.12 дүгээр зүйлийг тус тус үндэслэн мөн Тэнгэр Даатгал ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 сарын 19-ний өдрийн хурлын санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тэнгэр даатгал ХХК нь 2024 онд 7.1 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2024 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 67.12 төгрөг /жаран долоон төгрөг арван хоёр мөнгө/ буюу нийт 4,027,200,000.00 /дөрвөн тэрбум хорин долоон сая хоёр зуун мянган/ төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын дагуу ногдол ашгийг 2025 оны 04 сарын 30-ны дотор “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-н дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлж олгохыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Баянмөнхөд даалгасугай.
4. Энэхүү тогтоолын дагуу ногдол ашиг хуваарилсны дараа Компани нь төлбөрийн чадвартай байх бөгөөд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа болохыг дурдсугай.
5. Компанийн тухай хуулийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн энэхүү шийдвэрийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Баянмөнхөд даалгасугай.

Энэхүү шийдвэрийг 2025 оны 02-р сарын 19-ний өдөр бичгээр үйлдсэнийг гэрчлэн Компанийн тухай хуулийн 80.2 болон Компанийн дүрмийн 8.16-г тус тус үндэслэн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.ГАНТУЯА